

**Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАГНАЛ**

2026.07.28

Борхойн тал

Хагас жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/			
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.			
Тайлагнах хугацаа	2026 оны 01 дүгээр сарын 01-нээс 2026 оны 06 дугаар сарын 30		
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Э-Транс ложистикс ХК, ETR, 99117631		
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Хөрөнгийн бирж ТӨХК		
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Ачаа тээвэр, гаалийн нэг цэгийн үйлчилгээ		
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	ИХМОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК, 2014 оны 09 дүгээр сарын 17		
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	46,200,000 ширхэг		
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Тайлан бэлтгэсэн: Дотоод ажил хариуцсан ажилтан С.Ганбат Хянасан: Гүйцэтгэх захирал Ч.Энхболд		
1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/		
Санхүүгийн байдлын үзүүлэлт	Эргэлтийн хөрөнгийн дүн		3,811,491,503.64
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн		5,193,475,559.93
	Нийт хөрөнгийн дүн		9,004,967,063.57
	Богино хугацаат өр төлбөрийн дүн		726,881,230.73
	Урт хугацаат өр төлбөрийн дүн		2,540,798,634.46
	Өр төлбөрийн нийт дүн		3,267,679,865.19
	Эзэмшигчдийн өмчийн дүн		5,737,287,198.38

		Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	9,004,967,063.57
Орлогын тайлан		Борлуулалтын орлого (цэвэр)	1,138,763,298.94
		Нийт ашиг (алдагдал)	1,138,763,298.94
		Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(223,225,976.05)
		Татварын дараах ашиг (алдагдал)	(223,227,102.76)
		Нийт орлогын дүн	(223,227,102.76)
Өмчийн өөрчлөлтийн тайлан		Өмч	4,620,000,000.13
		Нэмж төлөгдсөн капитал	154,000,000.00
		Эздийн өмчийн бусад хэсэг	774,858,080.00
		Хуримтлагдсан ашиг	188,429,118.25
		Нийт дүн	5,737,287,198.38
Мөнгөн гүйлгээний тайлан		Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
		Мөнгөн орлогын дүн (+)	1,292,946,230.01
		Мөнгөн зарлага (-)	1,276,997,437.66
		Цэвэр мөнгөн гүйлгээ	15,948,792.35
		Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
		Мөнгөн орлогын дүн (+)	147,191,267.09
		Мөнгөн зарлагын дүн (-)	128,074,813.81
		Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	19,116,453.28
		Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
		Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	445,900,000.00
		Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	446,466,870.31
		Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(566,870.31)
		Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	34,498,375.32
		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	462,114,682.59
2.	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт		

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 07 дугаар сарын 08-ний 03 тоот тогтоолоор тус зөвлөлийн дэргэдэх аудитын хороог Ж.Энхтулга, Б.Оюунтуяа, Э.Уянга нарын бүрэлдэхүүнтэйгээр баталсан. Тус хорооноос компанийн санхүүгийн тайланг жилд нэг удаа жилийн эцсээр хэлэлцэхээр шийдвэрлэсний дагуу хагас жилийн санхүүгийн тайланг хэлэлцээгүй болно.

3.

Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал өмнөх жилийн мөн үеийнхээс нэлээдгүй хэмжээгээр буурч, 223 сая төгрөгний алдагдалтай ажилласан нь санхүүгийн байдлын тайлагналаар харагдаж байна. 2025 оны хагас жилийн байдлаар (2025 оны 07 сар хүртэл) 18,491 тээврийн хэрэгсэл Гаалийн хяналтын бүсэд нэвтэрч байсан бол энэ хагас жилд (2026 оны 07 сар хүртэл) 19,004 тээврийн хэрэгсэл нэвтэрч 513 тээврийн хэрэгслээр нэмэгдсэн үзүүлэлттэй байсан боловч Гаалийн хяналтын бүсэд хадгалагдаж байгаа ачаа бараанаас олох орлого буурсан мөн гаалийн байгууллагаас зарим төрлийн үнэ тарифаар төлбөр суутгахгүй байх шаардлага тавьж төлбөр авах боломжгүй болгосон, мөн гаалийн хяналтын бүсэд олон хоног зогсож хадгалалтын төлбөр нэмэх асуудлыг багасгаж байгаа зэрэг шалтгааны улмаас тодорхой хэмжээгээр орлого буурсан байдалтай байна. Үүнээс гадна үйл ажиллагаа явуулж байгаа орон нутаг, гаалийн байгууллагаас зам талбай, гадна орчны тохижолтыг сайжруулах, ухаалаг орц гарцын системийг суурилуулан ажилд оруулах зэрэг ажлын хүрээнд энэ хагас жилд нэлээн хэмжээний зардал гаргаж тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Жишээлбэл: Оффисын үүдэнд 2879м² үйлчлүүлэгч болон гааль, түрээслэгчдийн зогсоолын талбай, гаалийн хяналтын бүсийн хашаа дагуу 382м² явган хүний замыг 139,7 сая төгрөгөөр, орон нутгийн Борхойн баян бүрд орон нутгийн өмчит компаниар сухай, улиас, шар хуайс, хайлаас зэрэг 4,642 ширхэг мод бутыг 31,5 сая төгрөгөөр, Гаалийн хяналтын бүсийн зам талбайн арчлалтын хүрээнд 10,6 сая нийт 181,9 сая төгрөгийг зарцуулсан зэрэг томоохон бүтээн

д/д

Орлого

2025 оны хагас жил

2026 оны хагас жил

Зөрүү

1

Ачилтын орлого

13,610,545

0.00

2

Хадгалалт болон гарах хуудасны орлого

1,037,757,526

917,989,081

(119,768,445)

3

Түрээсийн орлого

27,200,000

40,650,000

13,450,000

4

Бусад орлого

685,040,366.17

332,760,490

(352,279,876.17)

байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн нь санхүүгийн зардал өсөхөд нөлөөлсөн гэж үзэж байна. Үндсэн үйл ажиллагаа болох шилжүүлэн ачилтын үйл ажиллагаа оны эхнээс бүрэн зогсож ямар нэгэн вагонд ачилт хийгдээгүй нь мөн орлого буурахад нөлөөлсөн байна. 2025 оны эхний хагас жилд экспортын 71 ачааг өөрийн пүүн дээрээ пүүлж 6,9 сая төгрөгийн орлого олж байсан бөгөөд тайлант хугацаанд экспортын төрөл нэмэгдсэнээр 481 ачааг пүүлж 24,08 сая төгрөгийн орлого олсон нь бусад орлогыг буурахаас сэргийлсэн байна.

3.1.

Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/

Нийт ашгийн хувь: Үйл ажиллагаанд өртөг тооцдоггүй

Ахиуц цэвэр ашиг : -19.6%

Цэвэр ашиг : -223.22 сая

Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE): -3.86%

хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл		
	Компанийн хувьд үйл ажиллагаа явуулж байгаа бүс нутагтаа газар нутгийн байрлал, автозам, үйлчилгээний хүрээ, хүртээмж, нөхцлийн хувьд давуу байдалтай ч үйлчилгээ авагч иргэд, аж ахуйн нэгж болон төмөр зам, гаалийн байгууллагын үйл ажиллагаанаас бүрэн хамааралтай тул үйл ажиллагааны доголдол байнга тохиолддог. Энэхүү доголдлыг тухай бүрт нь зохицуулах ажлуудыг тогтмол зохион байгуулж байсан боловч өнөөгийн байдлаар тодорхой үр дүнд хүрээгүй байгаа юм. Санхүүгийн эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэхийн тулд биржийн зах зээлд бонд босгох ажлыг хөрөнгө оруулалт, андеррайтерын компани Бидисек ҮЦК ХК-иар гүйцэтгүүлэн 3 тэрбум төгрөгийн хөрөнгө босгож ажиллаж байна. Зарим үйлчилгээний төлбөр, тариф-аар төлбөр авах боломжгүй болсон тул гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагаатай үнэ тарифын бодлогыг уялдуулан боловсонгуй болгох ажлыг хийхээр төлөвлөж байна.	
3.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Байхгүй
4.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
	Компанийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор нийт 3,000,000,000 (Гурван тэрбум) төгрөг хүртэлх үнийн дүн бүхий бондын хөтөлбөрийг дараах нөхцлийн дагуу Биржийн бус зах зээлд санал болгон гаргах ажлыг БиДиСек ҮЦК ХК-иар гүйцэтгүүлэн их хэмжээний хэлцэл хийгдсэн талаар компанийн болон Хөрөнгийн биржийн цахим хуудсанд журмын дагуу тавьж нийтэд мэдээлсэн болно.	
5.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл	
	Төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.	
6.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	
	- Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04 сарын 28-ны өдөр “ БиДиСек ҮЦК “ ХК-ийн цахим хурлын системээр дамжуулан зохион байгуулсан. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн: Компанийн 2025 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг батлах Компанийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах ТУЗ-ийн 2026 оны цалин урамшууллын төсөв батлах ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох Ногдол ашгийн талаар гаргасан шийдвэрийг танилцуулах - Хувьцаа эзэмшигчдийн хурлаар төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр шинээр Б.Оюунтуяа сонгогдсон бөгөөд гишүүдийн	

хурлыг 2026 оны 07 дугаар сарын 30-ны өдөр эцнээгээр зохион байгуулан төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, зөвлөлийн дэргэдэх хороодын гишүүдийг шинэчилж томилсон. Тухайн гишүүдийг томилохдоо компанийн засаглалын кодексийг баримтлан хороодын даргыг хараат бус гишүүдээр томилсон болно. - 2025 оны жилийн санхүүгийн үйл ажиллагаа, тайлагналд Их Монгол хөлөг аудит ХХК-иар аудит хийлгэн аудитын дүгнэлт тайлагналыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар аудитын компанийн төлөөлж ахлах аудитор Ариунбатыг оролцуулан хэлэлцүүлэн шийдвэрлэсэн. - Компанийн цахим хуудсыг тогтмол шинэчлэн хувьцаа эзэмшигчдийг холбогдох мэдээллээр ханган ажилласан. Цаашид цахим хуудас болон сошиал хуудаснуудын байнгын ажиллагааг хангаж ажиллахад анхаарч ажиллаж байна. - Компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлагналуудыг хууль журмаар тогтоосон хугацаанд нь гарган Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргүүлэн ажиллаж байгаа ба Хөрөнгийн биржийн цахим хуудсанд тайлагналуудыг тогтмол байршуулж байна. - Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээний тайланг Хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлж үнэлэлт дүгнэлт өгүүлж ажилласан.	
7. Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл	
Засаглалын үнэлгээний тайланг холбогдох журам зааварт заасныг баримтлан гаргаж хүргүүлсэн.	
Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:	
Овог, нэр: Чулуун Энхболд Албан тушаал: “Э-Транс логистикс” ХК-ийн гүйцэтгэх захирал Гарын үсэг: _____ (Тамга/тэмдэг) 	Овог, нэр: _____ Албан тушаал: “Их Монгол хөлөг аудит” ХХК аудитын компанийн гүйцэтгэх захирал Гарын үсэг: _____ (Тамга/тэмдэг)
Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:	
Овог, нэр: Содномцэрэн Ганбат Албан тушаал: Дотоод ажил, хяналт хариуцсан ажилтан Гарын үсэг: _____	